



АУДИТЫН КОД: САГ-2017/10/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитор П.Чанцалдулам

Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.5	Дотоод хяналт	7
2.6	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	8
2.7	Шилэн дансны мэдээлэл	9
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	10
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	10
2.9.1	Санхүүгийн тайлан гаргалтын талаар.....	10
2.9.2	Төсвийн шууд захирагч нарын 2016 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитаар хөндөгдсөн гол асуудлууд	10
2.9.3	2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлууд	11
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	15
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	15
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	16
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	16
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	16
3	Менежментийн захидал.....	17
3.1	Авлага, өглөгийн талаар.....	18
3.2	Бүртгэл тайлагналын талаар	19
3.3	Дотоод хяналтын талаар.....	20
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	21
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	21
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	22
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан	23
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	24
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	25

1 Аудитын гэрчилгээ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.04.25 № 749
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\0425SAG6.Docx

070156

Зөрчилгүй санал дүгнэлт

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд, /YAГ-2017/10/СТА-ТЕЗ/ санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 17-ноос 2017 оны

4 дүгээр сарын 21-ний хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор П.Чанцалдулам хэрэгжүүлэв.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2017 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 01/1830 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 17-ноос 2017 оны 4 дүгээр сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 4 дүгээр сарын 25-нд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны удирдлагад хүргүүлнэ.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны эрхэм зорилго нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн хандлагыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлж, байгалийн нөөц баялагийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь дараах бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

- Төрийн захиргааны удирдлагын газар;
- Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар;
- Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар;
- Ойн бодлого зохицуулалтын газар;
- Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газар;
- Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар;
- Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар;
- Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар;

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд УЦОШГ түүний харьяа орон нутгийн нийт 26 салбар нэгж, Тусгай хамгаалалттай газрын захиргаа болон Сав газрын захиргааны 48 байгууллага, яамны аппарат, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв, Байгаль орчин, уур амьсгалын сан, Ойн судалгаа хөгжлийн төв, Төрийн өмчит үйлдвэрийн газар 3, төсөл хөтөлбөр 6 нийт 87 байгууллага, хөрөнгө оруулалт, ойжуулалт, нөхөн сэргээлтийн барьцаа зэрэг дансдууд нэгтгэгдсэн байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.8-д “Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн” гэж заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайд төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна” гэж заасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагууд үйл ажиллагаандаа Байгаль орчныг хамгаалах тухай, Байгалийн ургамлын тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай, Ойн тухай, Амьтны тухай, Агаарын тухай, Усны тухай, Хог хаягдлын тухай зэрэг салбарын онцлог хууль эрхийн актуудыг мөрдөн ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2016 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгосон байна.

Мөн санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”, “Эдийн засгийн ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар баталсан “Төсвийн эх үүсвэрийн ангилал, Төсвийн бусад мэдээллийн болон Балансын дансны ангилал”, “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 2014 оны 55 дугаар тушаалаар “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”, “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Төсвийн орлогын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал, Зардлын зориулалт, арга хэмжээний ангилал”, “Журам шинэчлэн батлах тухай” 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгын маягт”-ыг 2 дугаар хавсралт зэрэг эрх зүйн актуудыг тус бүр мөрдөн ашиглаж байна.

Түүнчлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой холбогдох бусад хууль тогтоомжууд, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулахаар гаргасан Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг мөрдлөг болгон ажиллаж байна.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Тайлант онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/58 дугаар тушаалаар баталсан Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “дунд” буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардагдах магадлалтай гэсэн үнэлгээ гарсан. /ТАБ-СТА-В-2/

Тайлант хугацаанд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын харьяа байгууллагуудаас Хөвсгөл нуурыг хамгаалах төсөл, Экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээг голуудын сав газарт хэрэгжүүлэх төслүүд нь санхүүгийн бүртгэлээ Excel програмаар бүртгэж гаргасан бол Биологийн олон янзын байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох төсөл “Си ти эс” програм, Монгол ус ТӨААТҮГ нь Интерактив ХХК “Даймонд” програм, бусад байгууллагууд нь Санхүүгийн тооцоолох ХХК “Acolous 3.0” програмаар бүртгэлээ хөтөлж, санхүүгийн тайланг гаргаж, тайлагнажээ. Харин системийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны “Э-тайлан” програмаар нэгтгэн гаргасан байна.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулиудыг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсөв захирагчийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай

илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа./ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 9-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Аудитын нарийвчилсан горим, сорилыг хэрэгжүүлэх явцад гарсан зарим онцлог ажил гүйлгээнээс дурдвал дараах байдалтай байна.

Аудитаар Горхи тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2016 оны 1-12 сарын урсгал санхүүжилтийн харилцах дансны нийт 218.3 сая төгрөгийн зардлын ажил гүйлгээний цалин болон НДШ, ХХОАТ-ын шимтгэлээс бусад зардал болох 64.4 сая, жижиг мөнгөн сангийн 37.9 сая төгрөгийн ажил гүйлгээг тус бүр түүвэрлэн шалгахад дараах зөрчил илэрлээ.

- Батлагдсан орон тоог хэтрүүлэн, БОАЖС-ын тушаалаар 5 гэрээт ажилтан ажиллуулж, нийт 20.4 сая төгрөгийн цалин, 2.2 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн.
- Горхи тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн байранд байрладаг боловч түрээсийн зардал төлдөггүй, ашиглалтын зардал төлдөг байна. Гэвч Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвд 2016 онд төлсөн нийт 3.1 сая төгрөгийн ашиглалтын зардлыг 6 аж ахуй нэгж байгууллагад барааны үнэ гэсэн утгатай нэхэмжлэх баримтаар шилжүүлжээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А/04 дүгээр тушаалаар тус байгууллагын бүтэц, орон тоог баталж, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрыг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Газрын дарга-1, ахлах мэргэжилтэн-2, мэргэжилтэн-4 гэсэн орон тоотойгоор ажил үүргээ гүйцэтгэж иржээ.

Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг гарган батлуулж ажилласан бөгөөд дотоод аудитор нь харьяа байгууллагуудын хөрөнгийн хөдөлгөөн, мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээнд хяналт шалгалт хийж, ажлаа Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, түүний дэргэдэх Дотоод аудитын хороонд тайлагнасан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/31 дүгээр тушаалаар “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг шинэчлэн 12 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, гадаад шилжилт хөдөлгөөн, хөрөнгө акталж устгах, худалдан борлуулах, үнэлгээ тогтоох, хөрөнгийн тооллогын дүнг хэлэлцэж шийдвэр, дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг байна.

2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд яамны харьяа 21 байгууллагад төсвийн зарцуулалт, санхүүгийн хяналт шалгалт хийхээр батлагдсанаас 15 байгууллагад дотоод аудит болон санхүүгийн хяналт шинжилгээ хийсэн байна. Хэнтий, Сүхбаатар, Хөвсгөл, Говь-Алтай аймгуудын 6 газарт томилолтын зардалгүйгээс шалтгаалан төлөвлөгөөт аудит, санхүүгийн хяналт шалгалт хийгдээгүй боловч нэмэлтээр Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ, БОНХАЖЯ /хуучин нэрээр/-ны аппарат, Цэвэр агаар сан, сайдын багцын хөрөнгө оруулалтад хяналт шалгалт хийжээ.

Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь тайлант онд 319 төрлийн 675.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, алдаа дутагдлыг дахин гаргахгүй байх, цаашид анхаарч ажиллах 75 зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг тооцож, 9 байгууллага хугацаандаа зөвлөмжийн биелэлтээ ирүүлж, 8 байгууллагын хэрэгжилт ирүүлэх хугацаа нь болоогүй бөгөөд биелэлт нь 88 хувьтай байна.

Дотоод аудит, хяналт шалгалтаар хийсэн ажлын бичмэл болон тоон тайланг Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлсэн байна.

Аудитаар илэрсэн гол асуудлууд нь зарлагын эдийн засгийн ангилал зөрчсөн 227.5 сая төгрөг, анхан шатны баримтын бүрдэл дутуу 106.2 сая төгрөг, бодлогын баримт бичгээ шинэчлэн боловсруулж, мөрдөөгүй, гэрээгээр ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн орон тоог тухайн жилийн төсөвт батлагдсан гэрээтийн цалингийн санд багтаан томилж ажиллуулаагүй, үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллого, тооцоо бодолтыг акт үйлдэж, дүгнэлт гарган удирдлагад танилцуулж хэвшээгүй зэрэг нийтлэг алдаанууд гаргасан байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дотоод аудит, хяналт шалгалтыг бүрэн хийсэн боловч тайлант оны төлөвлөгөөгөө батлуулахдаа эрсдэл ихтэй харьяа байгууллага, тухайн жилийн төсөвт батлагдсан хөтөлбөр, арга хэмжээний зарцуулалтад анхаарлаа чиглүүлэн ажиллавал зохилтой байна.

2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу харьяа газар, нэгжүүдэд Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангаж, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 10,927.1 сая төгрөг, тайлант онд улсын төсвийн урсгал санхүүжилтээс 42,821.2 сая, хөрөнгө оруулалтын санхүүжилтээс 961.2 сая, нэмэлт санхүүжилтээс 5,440.6 сая, тусламжийн орлогоос 6,737.3 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 668.1 сая, нийгмийн даатгалын сангаас санхүүжих 119.7 сая, хүүгийн орлогоос 29.2 сая, бусад орлогоос 114.9 сая, Төрийн өмчит үйлдвэрийн газрын орлогоос 1,038.3 сая төгрөгийн эх үүсвэрийг тус тус орлогоор бүртгэж, урсгал шилжүүлэгт 2,405.4 сая, үйл ажиллагааны зардалд 48,331.9 сая, хөрөнгийн зардалд 4,524.5 сая, зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө 31.9 сая төгрөгийг тус тус зарцуулж, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 13,563.8 сая төгрөг байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны батлагдсан төсөв 54,114.0 сая төгрөг, тайлант онд гүйцэтгэлээр нийт 49,077.4 сая төгрөгийг зарцуулж, 5,036.5 сая төгрөг зарцуулагдаагүй байна.

Сангийн сайдын 2014 оны 5, 2015 оны 7, 2013 оны 73 дугаар тушаалын дагуу бараа, үйлчилгээний зардлын бүлэг хооронд зохицуулалт хийгдсэн боловч зардлын ангиллаар авч үзвэл нэмэгдэл цалин 9.2 сая, урамшуулал 2.0 сая, тэтгэвэр болон тэтгэмжийн даатгалын шимтгэл 84.3 сая, бичиг хэрэг 5.2 сая, БҮТЭЗ 10.9 сая, хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх 1.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,152.2 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

Гүйцэтгэлээр бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,152.2 сая төгрөгөөр хэтэрсэн шалтгаан нь экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээг голуудын сав газарт хэрэгжүүлэх тусламжийн төслийн санхүүжилтийн төлөвлөгөөг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газраас тавьж өгөөгүйгээс зардал хэтэрсэн байна.

Хөрөнгө оруулалтын зардалд батлагдсан 961.2 сая төгрөгийг бүрэн зарцуулсан ба өмнөх онд үүссэн векселиэрх төлбөрийн 429.6 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг барагдуулсан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан эсэх, хуулийн хэрэгжилтийн явцтай танилцахад:

Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2016 оны 11 дүгээр сард хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаас үзэхэд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 86 байгууллагаас 19 төрлийн нийт 1614 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 897, хугацаа хоцорч оруулсан 267, хугацаа болоогүй 81, огт оруулаагүй 369 мэдээлэл байгаа нь нийт мэдээллийн 55.5 хувь хугацаандаа оруулсан, 16.5 хувь хугацаа хоцорсон, 22.8 хувь цахим санд мэдээллээ огт оруулаагүй байна.

Мөн нийт байгууллагын 50.0 хувь нь улирлын тайланг хуульд заасан хугацаанд Сангийн яаманд цахим хэлбэрээр илгээгээгүй байна.

Харин шилэн дансны нэгдсэн цахим мэдээллийн санд “Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг”-ийг мэдээлэхээр заасны дагуу 5,844.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 9 гэрээний санхүүжилт 5,018.4 сая, “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”-г мэдээлэхээр заасны дагуу 8,642.6 сая төгрөгийн 27 орлогын гүйлгээ, 10,436.7 сая төгрөгийн 24 зарлагын гүйлгээг тус бүр ТЕЗ-ийн системийн хэмжээнд тайлант онд байршуулсан байна.

Цаашид дараах асуудлуудад анхаарал хандуулж ажиллах зөвлөмжийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны 01/2208 албан тоотой харьяа байгууллагуудын дарга, нягтлан бодогч нарт үүрэг болгосон байна. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим мэдээллийн санд оруулах мэдээллийг хугацаа хэтрүүлэх, огт мэдээлэхгүй орхигдуулах, шийдвэрүүдээ дутуу мэдээлэх зэрэг зөрчил гаргасан нь хэрэглэгчид мэдээллийг цогц байдлаар авах нөхцөл бүрдүүлэхгүй учраас хуулийн дагуу холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь оруулах;
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хэвшүүлэх талаар үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнууд нь хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулах, ажлын хариуцлагыг өндөржүүлэх;
- Байгууллагын мэдээлэл оруулах хэрэглэгчийн мэдээллийг тухай бүрт шинэчлэх, хяналт тавих үүргийг тодорхой болгох шаардлагатай байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 01/1256 албан тоотой Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, авсан арга хэмжээний биелэлтийг тус газар улирал бүр дүгнэх болсонтойгоор 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар хуулийн хэрэгжилтийг дүгнэж, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг бичиж, Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан бөгөөд хараахан албажаагүй хяналтын түвшинд байгаа учраас аудитын явцад танилцаж амжаагүй болно.

Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газраас 2016 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж 94.8 хувьтай гэж дүгнэсэн байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 11 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 9 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүн бүхий дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа./ТАБ-СТА-В-3/

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд урсгал төсвийн /БҮТЭЗ, Бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээ, багаж техник хэрэгсэл, цэвэр бохир ус, хичээл үйлдвэрлэлийн дадлага, нормын хувцас зөөлөн эдлэл, хөдөлмөр хамгааллын/ зардлаас нийт 726.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэжээ. Үүнд:

- Барилга байгууламж 10.9 сая төгрөг;
- Тээврийн хэрэгсэл 213.0 сая төгрөг
- Тоног төхөөрөмж 398.0 сая төгрөг;
- Тавилга эд хогшил 69.9 сая төгрөг;
- Бусад үндсэн хөрөнгө 33.6 сая төгрөг
- Програм хангамж 1.3 сая төгрөг байна.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитын явцад Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хэмжээнд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон устгах бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

2.9.1 Санхүүгийн тайлан гаргалтын талаар

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС-6, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам дахь заалтын дагуу мөр бүрээр нэгтгэх зарчмыг баримтлан ТШЗ-ийн аудит хийсэн санхүүгийн тайланг нэгтгэн толилуулсан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 51 ТШЗ, 1 ТТЗ, 1 Засгийн газрын тусгай сан, 6 төсөл хөтөлбөр, 3 ТӨҮГ-ын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 3.4 хувьд Үндэсний аудитын газар, 54.0 хувьд аймаг, орон нутаг дахь Төрийн аудитын газар, 16.1 хувьд нь хараат бус аудитын компани аудит хийж, 14.9 хувьд нь итгэл үзүүлж, 6.9 хувь нь аудит хамрагдаагүй, 4.7 хувь буюу 2 байгууллага болон бусад холбогдох данс түүврээр хамрагдсан байна.

2016 оны ТШЗ-дын санхүүгийн тайлангийн аудитаар аудит хийгдсэн 64 байгууллагын 60 байгууллагад “зөрчилгүй”, 4 байгууллагад “хязгаарлалттай” санал дүгнэлтийг өгсөн байна.

2.9.2 Төсвийн шууд захирагч нарын 2016 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитаар хөндөгдсөн гол асуудлууд

Төсвийн шууд захирагчдын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3,324.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 6.0 сая төгрөгийн зөрчилд 10 акт тавигдсан, 1,254.4

сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага бичигдэж, 1,098.7 сая төгрөгийн зөрчилд 88 зөвлөмж өгч, 965.4 сая төгрөгийн алдааг залруулсан байна.

2016 онд Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,098.7 сая төгрөгийн зөрчилд 88 зөвлөмж өгөгдсөний 40 нь бүртгэл, тайлагналтай холбоотой, 38 нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 2 нь бүртгэлийн бодлоготой холбоотой, 8 нь төлөвлөлт, хяналт, дотоод аудитын чанар, үр нөлөөг сайжруулахтай холбоотой байна.

Санхүүгийн тайлагнал болон хууль эрх зүйн асуудал

- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А/258 дугаар тушаалаар яамны ажилтнуудын хүүхдүүдийг 2016 оны 7 дугаар сарын 19-26-ны өдрийн хооронд аялуулахаар нийт 20.0 сая төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөрийн төсвөөс гаргаж, Монголын аялал, жуулчлалын холбоо төрийн бус байгууллагад шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолтой тус тус нийцэхгүй байна.
- Байгаль орчин, уур амьсгалын сангийн Удирдах зөвлөл нь тус сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, тухайн жилийн үйл ажиллагааны төсвийг батлах чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.
- БОАЖС /БОНХАЖС/-ын 2016 оны 112 дугаар тушаалаар Дэлхийн байгаль орчны өдрийг угтсан “Орон нутгийн байгаль хамгаалах чиглэлийн нөхөрлөлүүд, байгаль хамгаалагчдын чадавхыг бэхжүүлэх” ажлын хүрээнд нийт 38.0 сая төгрөгийг зарцуулахаар баталсан бөгөөд уг ажлын хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын сан нь “Чин Ундрах” ТББ-д ажил гүйцэтгэх гэрээгээр 26.0 сая төгрөг, “Уран хийцэт Харш” ХХК-д хамтран ажиллах /автомашин түрээслэх/ гэрээгээр 9.0 сая төгрөг, тээвэр шатахууны зардал 3.0 сая төгрөгийг “Магнай трейд” ХХК-д тус тус шилжүүлж нийт 38.0 сая төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу зарцуулжээ.
- БОАЖС /БОНХАЖС/-ын 2016 оны А/193 дугаар тушаалаар “Увс нуурын хотгор” хил дамнасан дархан газрын Монгол-Оросын холимог комиссын 3 дугаар хуралдааныг зохион байгуулах зардлыг Байгаль орчин, уур амьсгалын сангаас санхүүжүүлэхээр баталж, уг арга хэмжээнд зориулан нийт 15.0 сая төгрөгийн үнэ бүхий монгол гэрийг “Жоб-Ап” ХХК-иас худалдан авсан боловч хөрөнгийг данс бүртгэлд тусгаж орлого аваагүй байна.
- Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2016 оны төсөвт гадаад томилолтын зардал батлагдаагүй боловч бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлын төсвөөс 21.6 сая төгрөгийг гадаад томилолтын зардалд зарцуулж өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.
- Байгаль орчин, уур амьсгалын сан нь урьдчилж төлсөн зардал дансанд 2013, 2014 онд бүртгэгдсэн 633.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Байгууллага, ААН, иргэдтэй байгуулсан гэрээг дүгнээгүй, ажлын гүйцэтгэлийг тооцоогүй, олгосон урьдчилгаа болон урьдчилж гарсан зардлын тооцоог хийж тайлан бүртгэлд тусгаагүй байна.

ТШЗ-ийн хэмжээнд илэрсэн дээрх асуудлуудад байгууллагын удирдлага болон Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар судлан шийдвэрлэх шаардлагатай байгааг БОАЖЯ-ны удирдлагын анхааралд хандуулж байна.

2.9.3 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлууд

1. Тооцоо нийлж баталгаажуулаагүй нийт 487.0 сая төгрөгийн авлагаас 295.0 сая төгрөг нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны аппаратын, 180.6 сая төгрөг нь Монгол ус ТӨААТҮГ-ын авлагууд байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны аппаратын баталгаажуулаагүй авлага болох 295.0 сая төгрөгийн 282.2 сая төгрөг нь Цэвэр агаар сан татан буугдахад яамны аппаратад шилжиж ирсэн авлага байна. Үүнд:

- Нийслэлийн ЗДТГ, Цэвэр агаар сан, Тэнотэ ХХК-ийн хооронд 2011 оны 5 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан "Боловсруулах түлшний нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан түлш нийлүүлэх, урьдчилан худалдан авах" тухай 11/10 тоот гэрээний дагуу "Тэнота" ХХК-д санхүүжилтийн урьдчилгааг шилжүүлснээс 23.5 сая төгрөгийн авлага үүссэн;
- "Шарын гол Энэрго" ХХК-д 2011 онд түлшний үнийн урьдчилгаанд олгосон 282.1 сая төгрөгөөс 257.7 сая төгрөгийн авлага үүссэн;
- М.Хулангаас 2013 оны жижиг мөнгөн сангийн дутагдал 1.0 сая төгрөгийг авахаар авлагад бүртгэсэн бөгөөд Шүүхийн шатанд хянагдаж байна.

Монгол ус ТӨААТҮГ-ын 180.6 сая төгрөгийн авлагын 173.8 сая төгрөг нь тус байгууллага БОНХАЖС-ын /хуучин нэрээр/ 2015 оны "Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлсийг шинэчлэн батлах тухай" А/323 дугаар тушаалын дагуу ус ашиглуулах дүгнэлтийг гаргаж, 2015 онд 174.5 сая төгрөгийг нэхэмжилж, борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрч авлага үүсгэж бүртгэсэн боловч "Оюутолгой" ХК нь дээрх тушаалыг Хууль зүйн яаманд бүртгэгдээгүй, хүчин төгөлдөр бус эрх зүйн акт гэж үзэн БОНХС-ын /хуучин нэр/ 2016 оны А/157 дугаар тушаалаар үнэ тарифыг тооцож, 0.8 сая төгрөгийг төлж, үлдэгдэл төлбөрийг барагдуулаагүй байна.

Энэ нь УСНББОУС-1 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах естой-үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлагаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Батламж мэдэгдлийн *Оршин байх*: санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх; *Эрх ба үүрэг*: санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө/авлага/ уг аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, өр төлбөрийг төлөх үүрэгтэй байх" гэснийг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулан санхүүгийн тайланд тайлагнаж байхыг БОАЖЯ-ны удирдлагад зөвлөмж болгох;

Цэвэр агаар сан, Монгол ус ТӨААТҮГ-тай холбоотой авлагын асуудлуудыг БОАЖЯ-ны Санхүүгийн хэлтэс, Хуулийн хэлтэс, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрууд хамтран ажиллаж, баталгаажаагүй авлагын асуудлыг холбогдох байгууллагуудтай тооцоо нийлэх, шийдвэрлэх арга хэмжээг авч ажиллахыг БОАЖЯ-ны удирдлагад хандуулж, албан шаардлага өгөх;

2. Өглөгийн дансны үлдэгдэл 12,927.5 сая төгрөгөөс 511.4 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулалгүйгээр бүртгэлд тусгасны 192.8 сая төгрөг нь Байгаль орчин, уур амьсгалын сангийн, 186.9 сая төгрөг нь ойжуулалтын арга хэмжээ, хөтөлбөрийн өглөг, 39.2 сая төгрөг нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны аппаратын, 70.2 сая төгрөг нь Монгол ус ТӨААТҮГ болон Аялал жуулчлалын үндэсний төвийн өглөг байна. Тухайлбал:
 - Яамны аппаратын баталгаажаагүй өглөгийн 39.2 сая төгрөг нь БОНХАЖЯ-ны /хуучин нэр/ ТНБД-ын 2015 оны А/367 дугаар тушаалаар төвлөрсөн арга

хэмжээний хөтөлбөрийн дансны дуусгалтын балансыг гаргаж, яамны аппаратын балансад шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой 2014 онд үүссэн өглөг байна.

- Аялал жуулчлалын үндэсний төв ТӨҮГ 2015 онд Засгийн газрын 310 дугаар тогтоолоор татан буугдсан боловч БОАЖС-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэж, 32.7 сая төгрөгийн баталгаажуулалгүй өглөгийн үлдэгдэлтэй тайлагнагджээ.

Эдгээр нь УСНББОУС-1 27, 30, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, Батламж мэдэгдлийн *Оршин байх*: санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх; *Эрх ба үүрэг*: санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө/авлага/ уг аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, өр төлбөрийг төлөх үүрэгтэй байх” гэснийг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж холбогдох байгууллагуудтай тооцоо нийлэх, эзэн холбогдогч нь тодорхойгүй өглөгийн асуудлыг нотлох баримтад үндэслэн цэгцлэх арга хэмжээг авч ажиллахыг БОАЖЯ-ны удирдлагад зөвлөмж болгох;

3. Урьдчилгаа данс 2016 оны эхэнд 6,701.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 6,418.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 282.9 сая төгрөгөөр буурсан боловч уг дансны үлдэгдэл тооцооны 72.6 хувь буюу 4,657.0 сая төгрөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй, гэрээ дүгнээгүй байна.

Урьдчилж гарсан зардлын эцсийн үлдэгдлийн 87 хувь буюу 5,584.9 сая төгрөг нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны аппаратын, 9.8 хувь буюу 633.8 сая төгрөг нь Байгаль орчин, уур амьсгалын сангийн, 3 хувь буюу 195.6 сая төгрөг нь ойжуулалт, арга хэмжээний хөтөлбөр дансны үлдэгдэл байна. Тухайлбал:

- Цэвэр агаар сантай холбоотой 2013 онд үүссэн 781.6 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлын үлдэгдэл байгаа бөгөөд үүний 15.0 сая төгрөг нь Цэвэр агаар сангийн гүйцэтгэх захирлын 2014 оны 01 дүгээр албан бичгээр АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст хүргүүлсэн мэдээллээс үзэхэд жижиг мөнгөн сангийн дутагдал бөгөөд шүүхэд хэрэг үүсгэж, М.Хулангийн хавтаст хэрэгт бүртгэгдэн шалгагдаж байгааг өмгөөлөгчид нь албан тоотоор хүргүүлжээ. 747.0 сая төгрөг нь БОНХАЖЯ /хуучин нэр/-ны ТНБД-ын 2013 оны А/52 дугаар тушаалаар авто тээврийн хэрэгслээс ялгарах хорт хий, утааны тортогжилтыг бууруулах төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах гэрээний дүн 830.0 сая төгрөгөөс 747.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд гэрээний хугацаа дуусахад ажлын гүйцэтгэл 66 хувьтай байсан бөгөөд төхөөрөмжийн үр дүнг нийт 69 байгууллагаас 22 байгууллагыг сонгон санал асуулга авахад 90 хувь нь хөдөлгүүр доголдох, шатахуун зарцуулалт нэмэгдэх, гал гарсан, утаа буураагүй, цахилгаан зарцуулалт ихэссэн гэх мэт сөрөг дүгнэлтүүд гарсан байна. БОНХАЖЯ-ны ТНБД-ын 2014 оны А/294 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулагдан 2 удаа төхөөрөмж суурилуулсан хэд хэдэн байгууллагыг сонгон мэргэжлийн оношлогоо хийлгэсэн боловч ажлын хэсгийн дүгнэлт гараагүй, туршилт хийгдэж үр дүнтэй болох нь тогтоогдоогүй байна.

- Цэвэр агаар сантай холбоотой 2011 онд үүссэн 3,042.0 сая төгрөгийн урьдчилж гарсан зардал нь Ерөнхийлөгчийн дэргэдэх Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны ажлын албаны 2011 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 11/05 дугаар тогтоолоор Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний их багтаамжийн автобуснуудад дизель түлш болон шингэрүүлсэн нефтийн хийн хосолмол хэрэглээг нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлэхийг ЗТБХБЯ /хуучин нэр/ болон Цэвэр агаар санд даалгаснаар холбогдох байгууллагууд уг ажлыг эхлүүлж, 3,380.0 сая төгрөгийн гэрээг Туртелком ХХК-тай байгуулж 400 ширхэг төхөөрөмж нийлүүлж, 2011-2012 онд санхүүжилтийн 90 хувь болох 3,042.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, ажлын гүйцэтгэл 62.5 хувьтай, ажил нь зогссон байдалтай байна.

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2016 оны жилийн эцсийн аудитын тайланд урьдчилж төлсөн зардал дансанд 2013, 2014 онд бүртгэгдсэн 633.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд байгууллага, ААН, иргэдтэй байгуулсан гэрээг дүгнээгүй, ажлын гүйцэтгэлийг тооцоогүй, олгосон урьдчилгаа болон урьдчилж гарсан зардлын тооцоог хийж тайлан бүртгэлд тусгаагүй байна гэж албан шаардлага өгсөн байна.

Шийдвэрлэсэн нь: БОАЖЯ-ны Санхүүгийн хэлтэс, Хуулийн хэлтэс, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хамтран ажиллаж холбогдох байгууллагуудтай урьдчилж төлсөн зардлын үлдэгдлийг тооцоо нийлэх, ажил гүйцэтгэх гэрээг дүгнэх, бүртгэлийн асуудлыг цэгцлэх холбогдох арга хэмжээг авч ажиллахыг БОАЖЯ-ны удирдлагад хандуулж, албан шаардлага өгөх;

- 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах залруулгыг хийсэн болно. Тухайлбал:
 - ЗГСНТ-д БОНХАЖС /хуучин нэр/-ын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхэд нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 10,207.2 сая төгрөгийг Сангийн яамнаас авах авлагаар бүртгэсэн байсныг залруулан бүртгэсэнтэй холбоотойгоор өмнөх оны аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл залруулагдсан;
 - Монгол ус ТӨААТУҮГ болон Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн нэгж нь валютын харилцах дансны үлдэгдлийг Монгол банкны 2015 оны 12 дугаар сарын 30-ны хаалтын ханшаар авалгүй, тухайн өдрийн ханшаар бүртгэснээс ханшийн зөрүү үүсч, өмнөх оны аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэлээс 1.7 төгрөгийг хасаж залруулагдсан;
 - 25,000 төгрөгийн өглөгийг авлагаар бүртгэснээс шалтгаалан өмнөх оны аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн авлагын эхний үлдэгдэлээс хасч, өглөгийн эхний үлдэгдэлд нэмж залруулагдсан;
 - Дээрх 2 гүйлгээнээс шалтгаалан өмнөх оны аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн тайлант оны үр дүн (1.8) сая төгрөгөөр нэмэгдэж залруулагдсан;
 - Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитын явцад нийт 957.6 сая төгрөгийн залруулгыг хийсэн;

Шийдвэрлэсэн нь: УСНББОУС-1 27,30 болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан заавар журмын дагуу ажил гүйлгээг бүртгэлд үнэн зөв тусгаж, санхүүгийн нэгтгэсэн тайланг үнэн зөв стандартын дагуу тайлагнаж байхыг БОАЖЯ-ны удирдлагад зөвлөмж болгох;

- Төсвийн шууд захирагчдын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3,324.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 6.0 сая төгрөгийн зөрчилд 10 акт тавигдсан, 1,254.4 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага бичигдэж, 1,098.7 сая төгрөгийн зөрчилд 88 зөвлөмж өгч, 965.4 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан байна.

2016 онд төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,098.7 сая төгрөгийн зөрчилд 88 зөвлөмж өгөгдсөний 40 нь бүртгэл, тайлагналтай холбоотой, 38 нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 2 нь бүртгэлийн бодлоготой холбоотой, 8 нь төлөвлөлт, хяналт, дотоод аудитын чанар, үр нөлөөг сайжруулахтай холбоотой байна.

ТШЗ-ийн хэмжээнд 2016 онд илэрсэн асуудлуудыг аудитын тайланд хураангуйлан тэмдэглэж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны удирдлагын анхааралд хандуулж, дээрх асуудлуудыг давтан гаргахгүй байх ажлыг зохион байгуулж ажиллахыг тус байгууллагын удирдлага болон Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт зөвлөж байна.

Энэ нь Дотоод аудитын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино", мөн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Дотоод аудитын нэгж нь Төрийн аудитын байгууллагатай дараах хүрээнд хамтран ажиллаж болно 9.1.1-9.1.3 дахь заалт" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТШЗ-дын аудитаар илэрсэн асуудлуудад анхаарал хандуулан ажиллах, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ажлын шалгалтын үр дүнг сайжруулах, эрсдэл ихтэй харьяа байгууллага болон тухайн жилийн төсөвт суугдсан хөтөлбөр арга хэмжээний зарцуулалтад аудит хийж байх талаар БОАЖЯ-ны удирдлагад зөвлөмж болгох;

2.10 АНХААРАЛ ТАТАХҮЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд татан буугдсан Аялал жуулчлалын үндэсний төв ТӨҮГ-ын хөрөнгийн үлдэгдэл, санхүүгийн тайлан нь нэгтгэгдсэн бөгөөд Цэвэр агаар сан болон Аялал жуулчлалын үндэсний төв ТӨҮГ-ын нэгтгэгдсэн тайлангийн тоон үлдэгдэлүүд нь баталгаажуулаагүй, тооцоо нийлээгүй, гэрээ дүгнээгүй байгаа асуудалд анхаарал хандуулбал зохилтой байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

- БОАЖЯ-ны ойжуулалтын хөтөлбөр, арга хэмжээ нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд түүврээр үзэгдсэн бөгөөд цаг хугацааны хязгаарлагдмал нөхцлөөс шалтгаан уг хөтөлбөрийн зарцуулалтыг үзэж амжаагүй, санхүүгийн тайлангийн уялдааг шалгаж, нэгтгэлд хамруулсан болно. Уг хөтөлбөр нь 2017 оны төсвийн тухай хуулиар тус яамны аппаратын санхүүгийн тайланд нэгтгэгдэх тул дуусгалтын баланс болон 2016 оны санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнасан хөтөлбөр, арга хэмжээний зарцуулалтыг шалгах шаардлагатай.
- Мөн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж байгаа "Э-тайлан" програм хангамж хэвийн ажиллаагүй, санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлагнасан хөрөнгийн санхүүжилт, урсгал зардал, гадаад тусламжийн санхүүжилт, нэмэлт санхүүжилт болон бусад холбогдох тооцоог Сангийн яамтай тооцоо бүрэн нийлж баталгаажуулаагүй, Төв төрийн сангийн төсвийн хэлбэлзлийн тайлан эцэслэгдээгүй, нэгтгэлийн "Э-тайлан" програмаас хэвлэгдэж буй санхүүгийн байдлын тайланд Засгийн газрын хувь оролцооны дүн дутуу татагдсан зэрэг нь санхүүгийн нэгтгэсэн тайланг ЗГСНТ-д нэгтгүүлэхэд зарим тоон мэдээлэл өөрчлөгдөх эрсдэл үүсгэх магадлалтай байна.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛИЙН НЭГТГЭЛ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 2,882.5 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн бөгөөд дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар Яамны удирдлагын анхааралд хандуулж 3 зөвлөмж, 2 албан шаардлага өглөө.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас аудит хийж 5 зөвлөмж өгснийг 75 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 01/3178 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Төсвөөс санхүүждэг төрийн өмчит төсөвт байгууллага тул төлөвлөлтөөр материаллаг байдлын суурийг 2016 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлаар авч, түүний 2 хувиар тооцож, /56,855.2 х2%/ 1,137.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурийг дахин тооцоогүй бөгөөд материаллаг байдлын түвшинд өөрчлөлт ороогүй болно.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна гэж үзэж, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-д тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитаар илэрсэн нийт алдаа зөрчил нь 2,882.5 сая төгрөг бөгөөд аудитын дүгнэлтээр 60 байгууллагад “зөрчилгүй”, 4 байгууллагад “хязгаарлалттай” санал дүгнэлтийг өгсөн, “хязгаарлалттай” санал дүгнэлт авсан 4 байгууллагын нийт алдаа зөрчил нь 1,352.6 сая төгрөг бөгөөд сайдын батлагдсан төсвийн 4.3 хувийг эзэлж байгаа нь материаллаг байдлын түвшинд нөлөөлөх, шинж чанарын хувьд санхүүгийн нэгтгэсэн тайланг хязгаарлах үндэслэлгүй гэж үзлээ.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон Дотоод аудитын албаны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 Авлага, өглөгийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлагын эцсийн үлдэгдэл 942.4 сая төгрөг бөгөөд авлагын үлдэгдлийн 51.7 хувь буюу 487.0 сая төгрөг, өглөгийн эцсийн үлдэгдэл 12,927.5 сая төгрөг бөгөөд өглөгийн 3.9 хувь буюу 511.4 сая төгрөгийг тус тус тооцоо нийлж, актаар баталгаажуулалгүйгээр бүртгэлд тусгаж, тайлагнагдсан байна. Санхүүгийн нэгтгэсэн тайланд цэгцэлж, шийдвэрлэх шаардлагатай дараах өглөгүүд бүртгэлтэй байна. Тухайлбал:

- Яамны аппаратын баталгаажаагүй өглөгийн 39.2 сая төгрөг нь БОНХАЖЯ-ны /хуучин нэр/ ТНБД-ын 2015 оны А/367 дугаар тушаалаар төвлөрсөн арга хэмжээний хөтөлбөрийн дансны дуусгалтын балансыг гаргаж, яамны аппаратын балансад шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой 2014 онд үүссэн өглөг байна.
- Аялал жуулчлалын үндэсний төв ТӨҮГ 2015 онд Засгийн газрын 310 дугаар тогтоолоор татан буугдсан боловч БОАЖС-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэж, 32.7 сая төгрөгийн баталгаажаагүй өглөгийн үлдэгдэлтэй тайлагнагджээ.

Энэ нь УСНББОУС-1-27, 30, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Оршин байх, Эрх ба үүрэгийн батламж мэдэгдэлтэй тус тус хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэлүүд

-Ажил гүйлгээ данс бүртгэлд тусгагдаагүй байх;
-Холбогдох стандарт, хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх;

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож, санхүүгийн тайланд тайлагнасан авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулан санхүүгийн тайланд тайлагнаж байх;

Холбогдох байгууллага, хувь хүнтэй тооцоо нийлж, эзэн холбогдогч нь тодорхойгүй өглөгийн асуудлыг нотлох баримтад үндэслэн эрх бүхий байгууллагын шийдвэрээр цэгцлэх арга хэмжээг авч ажиллахыг БОАЖЯ-ны удирдлагад зөвлөмж болгох;

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 сарын 01-ны дотор өгөх;

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3.2 БҮРТГЭЛ ТАЙЛАГНАЛЫН ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №1
---------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах залруулгыг хийсэн болно. Тухайлбал:

- ЗГСНТ-д БОНХАЖС /хуучин нэр/-ын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхэд нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 10,207.2 сая төгрөгийг Сангийн яамнаас авах авлагаар бүртгэсэн байсныг залруулан бүртгэсэнтэй холбоотойгоор өмнөх оны аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл залруулагдсан;
- Монгол ус ТӨААТУУГ болон Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн нэгж нь валютын харилцах дансны үлдэгдлийг Монгол банкны 2015 оны 12 дугаар сарын 30-ны хаалтын ханшаар авалгүй, тухайн өдрийн ханшаар бүртгэснээс ханшийн зөрүү үүсч, өмнөх оны аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэлээс 1.7 төгрөгийг хасаж залруулагдсан;
- 25,000 төгрөгийн өглөгийг авлагаар бүртгэснээс шалтгаалан өмнөх оны аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн авлагын эхний үлдэгдэлээс хасч, өглөгийн эхний үлдэгдэлд нэмж залруулагдсан;
- Дээрх 2 гүйлгээнээс шалтгаалан өмнөх оны аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн тайлант оны үр дүн (1.8) сая төгрөгөөр нэмэгдэж залруулагдсан;
- Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитын явцад нийт 957.6 сая төгрөгийн залруулгыг хийсэн;

Энэ нь УСНББОУС-1 27, 30 болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан заавар журмыг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэлүүд

-Ажил гүйлгээ данс бүртгэлд тусгагдаагүй байх;
-Холбогдох стандарт, хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх;

ҮАГ-ын зөвлөмж

УСНББОУС-1 27, 30 болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан заавар журмын дагуу ажил гүйлгээг бүртгэлд үнэн зөв тусгаж, санхүүгийн нэгтгэсэн тайланг үнэн зөв стандартын дагуу тайлагнаж байх;

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 сарын 01-ны дотор өгөх;

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3.3 Дотоод хяналтын талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
-----------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Төсвийн шууд захирагчдын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3,324.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 6.0 сая төгрөгийн зөрчилд 10 акт тавигдсан, 1,254.4 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага бичигдэж, 1,098.7 сая төгрөгийн зөрчилд 88 зөвлөмж өгч, 965.4 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан байна.

2016 онд төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,098.7 сая төгрөгийн зөрчилд 88 зөвлөмж өгөгдсөний 40 нь бүртгэл, тайлагналтай холбоотой, 38 нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 2 нь бүртгэлийн бодлоготой холбоотой, 8 нь төлөвлөлт, хяналт, дотоод аудитын чанар, үр нөлөөг сайжруулахтай холбоотой байна.

ТШЗ-ийн хэмжээнд 2016 онд илэрсэн асуудлуудыг аудитын тайланд хураангуйлан тэмдэглэж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны удирдлагын анхааралд хандуулж, дээрх асуудлуудыг давтан гаргахгүй байх ажлыг зохион байгуулж ажиллахыг тус байгууллагын удирдлага болон Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт зөвлөж байна.

Энэ нь Дотоод аудитын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1, мөн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-9.1.3 дахь заалт” -тай хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэлүүд

-Дансны бичилт буруу хийгдсэн байх;
-Холбогдох стандарт, хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх;
-Дотоод аудитын дүрмийг хэрэгжүүлэх;

ҮАГ-ын зөвлөмж

ТШЗ-дын аудитаар илэрсэн асуудлуудад анхаарал хандуулан ажиллах, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шалгалтын үр дүнг сайжруулах, эрсдэл ихтэй харьяа байгууллага болон тухайн жилийн төсөвт суугдсан хөтөлбөр арга хэмжээний зарцуулалтад аудит хийж байх;

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 сарын 01-ны дотор өгөх;

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

4 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мян.төг)

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	2015 ОНЫ 12-Р САРЫН 31	2016 ОНЫ 12-Р САРЫН 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	24,249,770.2	27,647,477.6
МӨНГӨН ХӨРӨНГӨ	10,927,056.7	13,563,828.4
АВЛАГА	934,791.9	942,383.2
УРЬДЧИЛГАА	6,701,155.6	6,418,770.0
БАРАА МАТЕРИАЛ	5,605,804.1	5,862,612.7
НӨӨЦИЙН БАРАА	80,961.9	859,883.2
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	33,117,077.6	39,169,391.2
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	33,117,077.6	39,169,391.2
Биет хөрөнгө	32,907,976.7	39,043,923.3
Биет бус хөрөнгө	209,100.9	125,467.9
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	57,366,847.8	66,816,868.8
НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,388,152.3	12,927,505.5
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,388,152.3	12,927,505.5
Богино хугацаат зээлийн өглөг	35,000.0	0.0
Өглөг	15,284,725.3	1,393,961.6
Урьдчилж орсон орлого	68,427.0	11,533,543.9
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	41,978,695.5	53,889,363.3
Засгийн газрын хувь оролцоо	41,978,695.5	53,889,363.3
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	26,405,683.9	26,736,361.0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	30,166.5	8,296,105.3
Хуримтлагдсан үр дүн	13,373,155.8	16,698,568.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,169,689.3	2,158,328.5
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	57,366,847.8	66,816,868.8

4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мян.төг)

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ТОДРУУЛГА	2015 ОНЫ 12-Р САРЫН 31	2016 ОНЫ 12-Р САРЫН 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		63,717,105.9	58,178,776.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	10,482,874.0	10,299,043.0
Нийтлэг татварын бус орлого		5,834,462.3	3,466,450.0
Хөрөнгийн орлого		46,784.9	79,169.2
Тусламжийн орлого		4,601,626.8	6,753,423.7
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		53,234,232.0	47,879,733.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	66,410,039.1	54,899,064.1
УРСГАЛ ЗАРДАЛ		60,694,455.1	54,207,886.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		58,511,922.4	52,192,757.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		25,598,908.1	25,062,855.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,862,641.4	2,730,645.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,155,460.2	1,437,804.2
Хангамж, бараа материалын зардал		1,703,716.0	1,376,523.6
Нормативт зардал		54,074.9	32,490.8
Эд хогшил, урсгал засварын зардал		1,510,038.6	502,206.5
Томилолт, зочны зардал		1,387,636.8	611,719.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		14,601,799.8	13,100,645.5
Бараа үйлчилгээний бусад зардал		9,637,646.7	7,337,865.6
ТАТААС		91,777.2	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,090,755.4	2,015,129.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		5,715,584.0	691,177.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		(2,692,933.2)	3,279,711.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		34,506.4	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		904,668.0	176,024.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		(3,563,094.8)	3,103,687.7

4.3 Аудит хийгдсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мян.төг)

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН	ЦӨӨНХИЙН ХУВЬ ОРОЛЦОО	НИЙТ ЦЭВЭР ХӨРӨНГӨ /ӨМЧ
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	45,829,623.7	-	45,829,623.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(839,258.3)	-	(839,258.3)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,990,365.5	-	44,990,365.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(137,331.3)	-	(137,331.3)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	688,756.1	-	688,756.1
Тайлант үеийн үр дүн	(3,563,094.8)	-	(3,563,094.8)
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,978,695.5	-	41,978,695.5
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	41,978,695.5	-	41,978,695.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	8,477,438.1	-	8,477,438.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	50,456,133.6	-	50,456,133.6
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(11,125.6)	-	(11,125.6)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	340,667.6	-	340,667.6
Тайлант үеийн үр дүн	3,103,687.7	-	3,103,687.7
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	53,889,363.3	-	53,889,363.3

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мян.төг)		
ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	2015 ОНЫ 12-Р САРЫН 31	2016 ОНЫ 12-Р САРЫН 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	70,021,937.0	57,930,463.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,020,643.2	8,587,137.0
Нийтлэг татварын бус орлого	553,102.0	1,849,826.2
Тусламжийн орлого	4,467,541.3	6,737,310.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	65,001,293.8	49,343,326.2
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	55,558,596.5	50,737,294.1
УРСГАЛ ЗАРДАЛ	55,558,596.5	50,737,294.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,937,103.4	48,331,868.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,627,539.0	24,836,657.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,873,402.0	2,768,510.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,308,721.9	1,544,276.8
Хангамж, бараа материалын зардал	1,190,423.3	1,008,050.5
Нормативт зардал	32,901.5	74,572.4
Эд хогшил, урсгал засварын зардал	1,147,240.0	1,429,523.8
Томилолт, зочны зардал	1,109,578.0	440,489.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,775,455.4	15,362,350.5
Бараа үйлчилгээний бусад зардал	3,871,842.2	867,437.2
ТАТААС	2,141,920.9	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,479,572.2	2,405,425.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	14,463,340.5	7,193,169.2
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,505,494.4	4,524,502.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,505,494.4	4,524,502.3
Дотоод эх үүсвэрээр	4,505,494.4	4,524,502.3
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(4,505,494.4)	(4,524,502.3)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(31,895.1)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	31,895.1
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	9,957,846.0	2,636,771.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	969,210.7	10,927,056.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,927,056.7	13,563,828.4

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мян.төг)

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	ЗӨРҮҮ	ХУВЬ
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	54,113,966.8	49,077,420.7	5,036,546.1	90.7
УРСГАЛ ЗАРДАЛ	46,330,551.4	45,288,206.2	1,042,345.2	97.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,182,904.0	44,280,153.2	(97,249.2)	100.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,363,662.6	24,175,182.1	188,480.5	99.2
Үндсэн цалин	22,646,755.6	22,513,410.2	133,345.4	99.4
Нэмэгдэл	13,862.5	23,097.8	(9,235.3)	166.6
Унаа хоолны хөнгөлөлт	1,218,437.8	1,195,905.1	22,532.7	98.2
Гэрээт ажлын хөлс	484,606.7	442,769.1	41,837.6	91.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,681,038.4	2,663,834.9	17,203.5	99.4
Тэтгэврийн даатгал	1,715,744.1	1,792,995.4	(77,251.3)	104.5
Тэтгэмжийн даатгал	193,059.1	200,059.4	(7,000.3)	103.6
ҮОМШӨ-ний даатгал	241,323.5	208,133.0	33,190.5	86.2
Ажилгүйдлийн даатгал	48,264.5	43,855.4	4,409.1	90.9
Эрүүл мэндийн даатгал	482,647.2	418,791.6	63,855.6	86.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,554,496.5	1,451,719.6	102,776.9	93.4
Гэрэл, цахилгаан	444,845.8	441,169.1	3,676.7	99.2
Түлш, халаалт	663,336.2	612,588.6	50,747.6	92.4
Цэвэр, бохир ус	83,007.3	69,507.0	13,500.3	83.7
Байрны түрээс	363,307.2	328,454.8	34,852.4	90.4
Хангамж, бараа материалын зардал	680,452.3	679,332.5	1,119.8	99.8
Бичиг хэрэг	102,908.7	108,162.7	(5,254.0)	105.1
Тээвэр, шатахуун	367,095.0	357,776.7	9,318.3	97.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	158,581.9	150,806.9	7,775.0	95.1
Ном, хэвлэл	98.0	98.0	-	100.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,864.6	2,689.4	175.2	93.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	48,904.1	59,798.8	(10,894.7)	122.3
Нормативт зардал	68,187.6	67,171.5	1,016.1	98.5
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33,200.0	33,193.6	6.4	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	34,987.6	33,977.9	1,009.7	97.1
Эд хогшил, урсгал засварын зардал	1,414,011.1	1,388,503.5	25,507.6	98.2
Багаж, техник, хэрэгсэл	1,256,773.2	1,253,976.8	2,796.4	99.8
Тавилга	3,825.0	-	3,825.0	-
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	21,649.5	21,172.4	477.1	97.8
Урсгал засвар	131,763.4	113,354.3	18,409.1	86.0
Томилолт, зочны зардал	307,156.0	302,589.8	4,566.2	98.5
Дотоод албан томилолт	307,156.0	302,589.8	4,566.2	98.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,743,851.3	12,880,646.3	(1,136,795.0)	109.7

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,484,347.5	12,630,943.3	(1,146,595.8)	110.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	31,027.3	28,884.7	2,142.6	93.1
Даатгалын үйлчилгээ	30,921.7	29,539.2	1,382.5	95.5
Тээврийн хэрэгслийн татвар	11,687.9	10,224.4	1,463.5	87.5
Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,091.5	2,209.3	882.2	71.5
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	111,016.9	110,708.2	308.7	99.7
Газрын төлбөр	22,735.6	20,258.6	2,477.0	89.1
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	21,022.9	19,885.4	1,137.5	94.6
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	28,000.0	27,993.3	6.7	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,370,048.2	671,173.2	698,875.0	49.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,261,306.6	562,431.6	698,875.0	44.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	108,741.6	108,741.6	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,147,647.4	1,008,052.9	1,139,594.5	46.9
Засгийн газрын урсгал шилжүүлэг	160,957.5	160,178.4	779.1	99.5
Засгийн газрын гадаад шилжүүлэг	160,957.5	160,178.4	779.1	99.5
Бусад урсгал шилжүүлэг	1,986,689.9	847,874.6	1,138,815.3	42.7
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	87,311.6	77,833.9	9,477.7	89.2
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,899,378.3	770,040.7	1,129,337.6	40.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,783,415.4	3,789,214.5	3,994,200.9	48.7
Барилга байгууламж	2,734,250.6	961,214.5	1,773,036.1	35.2
Тоног төхөөрөмж	620,042.9	-	620,042.9	69.1
Бусад хөрөнгө	4,429,121.9	2,828,000.0	1,601,121.9	63.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	54,113,966.8	50,329,815.9	3,784,150.9	93.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,637,214.9	43,224,816.1	2,412,398.8	94.7
Улсын төсвөөс санхүүжих	45,637,214.9	43,224,816.1	2,412,398.8	94.7
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	280,503.8	367,689.0	(87,185.2)	131.1
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	247,003.8	313,948.0	(66,944.2)	127.1
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,500.0	53,740.9	(20,240.9)	160.4
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	8,196,248.1	6,737,310.8	1,458,937.3	82.2
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	8,196,248.1	6,737,310.8	1,458,937.3	82.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		693,798.7	(693,798.7)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,946,193.9	(1,946,193.9)	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	5,780.0	5,780.0	-	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	86.0	86.0	-	100.0
Төсвийн байгууллага	86.0	86.0	-	100.0
Төсвөөс гадуур байгууллага	-	-	-	-
АЖИЛЛАГСАДЫН ТОО	2,847.0	2,847.0	-	100.0
Удирдах ажилтан	134.0	134.0	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	2,400.0	2,400.0	-	100.0
Үйлчлэх ажилтан	257.0	257.0	-	100.0
Гэрээт ажилтан	56.0	56.0	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	2,847.0	2,847.0	-	100.0

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	774.0	774.0	-	100.0
ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	16.0	16.0	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2,001.0	2,001.0	-	100.0
Гэрээт ажилтан	56.0	56.0	-	100.0